СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СБА-2025/079-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2025 он | Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа<br>Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Нарантуяа<br>Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn<br>Аудитор: О.Барчидгүнсэн<br>Утас: 99797799 Цахим хаяг: Barchidgunseno@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ............................................................. 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ......................... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ................Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН ....................................................Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл ........................................................Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудалError! Bo
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтError! Bookmark not defi
4.5.1 Завсрын аудитын талаар ..................................Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..............Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........................................................................................ 9
5.1 Зөвлөмж...................................................................................................... 9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.................................... 9

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn


2025.02.25 № 88

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Р.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3,000 төгрөг болгон шинэчлэн тогтоож, уг шийдвэрийг 2024 оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад нийт хоолны зардал 6.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Төрийн сангийн гүйлгээ хаагдсаны дараа хүүхдийн хоолны зардалд 2.0 сая, сургалтын хөтөлбөрт 71.7 сая, нийт 73.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон нь төсвийн төлөвлөлтийн алдаа болон хэмнэлтээс үүдэлтэй байна. Дээрх хөрөнгө нь цалин, хоолны зардлуудад хуваарилагдсан бөгөөд тайлант хугацаанд өр төлбөр үүсээгүй байхад шууд хуваарилагдсан байна. Иймд боловсролын байгууллагын дээд шатны төсвийн захирагчийн төсвийн төлөвлөлт, үлдэгдэлд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарыг урьж, орон нутагт эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулснаар 274 иргэн хамрагдсан бөгөөд үүний үр дүнд тус байгууллагын ЭМДС-аас авах санхүүжилт нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлжээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ДАВАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 174,398,438.95 | 254,590,595.07 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 72,683,324.66 | 105,189,556.78 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 72,683,324.66 | 105,189,556.78 |
| 3121 | Төгрөг | 72,683,324.66 | 105,189,556.78 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 72,683,324.66 | 105,189,556.78 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 101,715,114.29 | 149,401,038.29 |
| 354 | Хангамжийн материал | 101,715,114.29 | 149,401,038.29 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 906,000.00 | 1,767,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 63,289,504.29 | 109,589,004.29 |
| 35460 | Хүнсний материал | 424,000.00 | 948,924.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 37,095,610.00 | 37,095,610.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 242,748,437.78 | 217,998,887.46 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 242,748,437.78 | 217,998,887.46 |
| 392 | Биет хөрөнгө | 227,968,437.78 | 203,518,887.46 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 157,466,463.13 | 157,466,463.13 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (32,831,054.76) | (37,714,033.08) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,430,784.84 | 70,430,784.84 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (25,690,213.12) | (37,361,937.40) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,889,569.75 | 39,889,569.75 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,558,016.83) | (18,556,364.63) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 55,894,000.00 | 55,894,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (28,258,500.23) | (30,155,000.15) |
| 39217 | Ном | 3,625,405.00 | 3,625,405.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 14,780,000.00 | 14,480,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (90,000.00) | (390,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,370,000.00 | 13,370,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 417,146,876.73 | 472,589,482.53 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,500,000.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,500,000.00 | - |
| 413 | Өглөг | 1,500,000.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 1,500,000.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,500,000.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 415,646,876.73 | 472,589,482.53 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 415,646,876.73 | 472,589,482.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 88,549,832.39 | 88,549,832.39 |
| 51101 | Өмч: - төрийн | 88,549,832.39 | 88,549,832.39 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 225,201,116.31 | 282,143,722.11 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 85,210,505.46 | 225,201,116.31 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 139,990,610.85 | 56,942,605.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 101,895,928.03 | 101,895,928.03 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 417,146,876.73 | 472,589,482.53 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 663,861,766.00 | 852,434,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 86,269,766.00 | 39,200,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 86,269,766.00 | 39,200,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 73,570,056.00 | - |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 12,699,710.00 | 39,200,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 577,592,000.00 | 813,234,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 552,892,000.00 | 788,234,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 552,892,000.00 | 788,234,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 24,700,000.00 | 25,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,700,000.00 | 25,000,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 523,871,155.15 | 795,491,494.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 523,871,155.15 | 795,491,494.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 523,862,158.93 | 795,480,983.72 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 358,998,561.40 | 573,268,708.54 |
| 210101 | Үндсэн цалин | 253,886,793.24 | 373,984,452.91 |
| 210102 | Нэмэгдэл | 92,152,397.66 | 179,942,097.03 |
| 210104 | Урамшуулал | 12,959,370.50 | 19,342,158.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,074,131.03 | 72,098,165.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,976,163.05 | 48,721,223.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,526,683.96 | 5,615,644.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,821,327.08 | 3,491,763.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 696,689.27 | 2,805,716.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,053,267.67 | 11,463,817.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,691,003.78 | 19,679,869.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,151,095.78 | 4,686,229.52 |
| 210302 | Түлш, халаалт | 12,044,908.00 | 11,993,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,495,000.00 | 3,000,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 68,242,490.20 | 75,216,258.00 |
| 210502 | Хоол, хүнс | 68,242,490.20 | 75,216,258.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,316,000.00 | 3,154,120.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,316,000.00 | 3,154,120.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 990,778.00 | 811,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 990,778.00 | 811,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,549,194.52 | 51,252,561.72 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,719,100.00 | 19,733,511.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,678,700.00 | 6,769,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,151,394.52 | 24,749,550.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,996.22 | 10,510.48 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 8,996.22 | 10,510.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,996.22 | 10,510.48 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 139,990,610.85 | 56,942,605.80 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 139,990,610.85 | 56,942,605.80 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 577,592,000.00 | 813,234,100.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 577,592,000.00 | 813,234,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 552,892,000.00 | 788,234,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 552,892,000.00 | 788,234,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 24,700,000.00 | 25,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,700,000.00 | 25,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 517,877,360.63 | 780,727,867.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 517,877,360.63 | 780,727,867.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 517,868,364.41 | 780,717,357.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 358,998,561.40 | 573,268,708.54 |
| 210101 | Үндсэн цалин | 253,886,793.24 | 373,984,452.91 |
| 210102 | Нэмэгдэл | 92,152,397.66 | 179,942,097.03 |
| 210104 | Урамшуулал | 12,959,370.50 | 19,342,158.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,074,131.03 | 72,098,165.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,976,163.05 | 48,721,223.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,526,683.96 | 5,615,644.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,821,327.08 | 3,491,763.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 696,689.27 | 2,805,716.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,053,267.67 | 11,463,817.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,691,003.78 | 19,989,869.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,151,095.78 | 4,996,229.52 |
| 210302 | Түлш, халаалт | 12,044,908.00 | 11,993,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,495,000.00 | 3,000,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 68,666,490.20 | 75,741,182.00 |
| 210502 | Хоол, хүнс | 68,666,490.20 | 75,741,182.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 4,999,620.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,999,620.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 990,778.00 | 2,311,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 990,778.00 | 2,311,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,447,400.00 | 32,308,511.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,460,700.00 | 25,539,011.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,986,700.00 | 6,769,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,996.22 | 10,510.48 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 8,996.22 | 10,510.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,996.22 | 10,510.48 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 59,714,639.37 | 32,506,232.12 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 420,000.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 420,000.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 420,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 420,000.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (420,000.00) | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 59,294,639.37 | 32,506,232.12 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 13,388,685.29 | 72,683,324.66 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 72,683,324.66 | 105,189,556.78 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 79,557,832.39 | 101,895,928.03 | 85,210,505.46 | 0.00 | 266,664,265.88 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **79,557,832.39** | **101,895,928.03** | **85,210,505.46** | **0.00** | 266,664,265.88 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 8,992,000.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 8,992,000.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 139,990,610.85 | 0.00 | 139,990,610.85 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **88,549,832.39** | **101,895,928.03** | **225,201,116.31** | **0.00** | 415,646,876.73 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **88,549,832.39** | **101,895,928.03** | **225,201,116.31** | **0.00** | 415,646,876.73 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **88,549,832.39** | **101,895,928.03** | **225,201,116.31** | **0.00** | 415,646,876.73 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 56,942,605.80 | 0.00 | 56,942,605.80 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **88,549,832.39** | **101,895,928.03** | **282,143,722.11** | **0.00** | 472,589,482.53 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 885,563,200.00 | 780,717,357.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 885,563,200.00 | 780,717,357.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 885,563,200.00 | 780,717,357.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 663,603,800.00 | 573,268,708.54 |
| 210101 | Үндсэн цалин | 456,968,900.00 | 373,984,452.91 |
| 210102 | Нэмэгдэл | 199,480,100.00 | 179,942,097.03 |
| 210104 | Урамшуулал | 7,154,800.00 | 19,342,158.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 77,275,600.00 | 72,098,165.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,548,900.00 | 48,721,223.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,180,500.00 | 5,615,644.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,091,000.00 | 3,491,763.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,091,000.00 | 2,805,716.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,364,200.00 | 11,463,817.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,000,000.00 | 19,989,869.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,000,000.00 | 4,996,229.52 |
| 210302 | Түлш, халаалт | 12,000,000.00 | 11,993,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 82,791,200.00 | 75,741,182.00 |
| 210502 | Хоол, хүнс | 82,791,200.00 | 75,741,182.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 4,999,620.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,999,620.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,311,300.00 | 2,311,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,311,300.00 | 2,311,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,581,300.00 | 32,308,511.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,811,700.00 | 25,539,011.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,769,600.00 | 6,769,500.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 813,065,900.00 | 813,223,589.52 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 813,065,900.00 | 813,223,589.52 |

| | | | |
|---|---|---|---|
| 122005 | Улсын төсвөөс санхүүжих | 813,065,900.00 | 813,223,589.52 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 72,683,324.66 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 105,189,556.78 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн үндсэн хөрөнгө бараа материалын үлдэгдэлтэй холбоотой зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

### 3.1.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 47 нэр төрлийн 51,797.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа боловч дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

***Өгсөн зөвлөмж*:**

Дахин үнэлэгдэх боломжгүй хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр оруулж, актлах саналыг холбогдох байгууллагад саналыг хүргүүлэх гэдэг агуулгаар байвал ямар вэ, зөвхөн ашиглагдахыг нь авч үзсэн байна.

### 3.1.2 Илрүүлэлт:

Ашиглагдахгүй олон жил болсон шаардлага хангахгүй бараа материалыг үлдэгдлээр илэрхийлжээ.

***Өгсөн зөвлөмж*:**

Тооллогыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, баримт материалыг иж бүрэн бүрдүүлж, шаардлага хангахгүй бараа материалыг "Өмч хамгаалах комисс"-ийн санал дүгнэлтийг үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1[1], 72.4.2[2], 72.4.4[3], Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6[4] дахь заалттай нийцүүлэн шийдвэрлэсэн байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

[1] эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;
[2] тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;
[3] комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;
[4] эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 47 нэр төрлийн 51,797.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй ,дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Ашиглагдахгүй олон жил болсон шаардлага хангахгүй бараа материалыг үлдэгдлээр илэрхийлжээ. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 2 | 0 | | | | | | | | | | |